НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 02 өдөр Дугаар А/89. Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 6 дугаар хорооны "Мөнх-Үжин" өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 14,443,000.00 (арван дөрвөн сая дөрвөн зуун дөчин гурван мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвд балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн 6 дугаар хорооны "Мөнх-Үжин" өрхийн эрүүл мэндийн төв (З.Туяа)-д зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв (Ц.Бямбасүрэн)-д даалгасугай

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА В.ОЮУМАА

الجنيناوتشلون ناطق م ٥٨ ـك ٢٥ — ٩ ربيع الآخر ٢٥٣ ٥ ٢٤٥٤
الجنيناوتشلون ناطق

وسنتصل مفوضنا لدى ٦ ضنتش ناطكسم ٩
لدى المخاجر لدى
ميلنيا–ماحدا: ٤ مفوضنا لدى ماهلى ميلشو لدى مفوضنا م ماخاجر لدى
ضوض ناطكسم ٩ ضنتش ٣٥ ٥٨ ـك ٢٥ — ٩ ربيع الآخر ٢٥٣ ٥ ٢٤٥٤

ميلنتيا ماجلا م لدمل لدناتا . أفضل مفوضاهنا م أنزاح . مفلم ٩ ماضفاضفيأ لدى مضل ناطكر لدى ٤٩ ضنتش لدتا م ٢٠٩٤ ضلت ١٤٠٩ ضنتش لدتا . مفتق لدى ضيلم ماضل أفضل م ماجلح لدى مضل ناطكر لدى ٤٩ ضنتش لدتا م ٤٠٩٢ ضلت ١٤٠٩ ضنتش لدتا . أنتاجيا م ماخاجر لدى مفاضلهاجتاح م ناطكا م مفتزلهاجتاح م ٤٦٥٢ م ٤٦٥٢ ضنتش مضنتيا لدتى وضومشمسيا : أنتاجيا م ماخاجتفى ناطكر لدى ماضلهاح م ماجلح لدى ماضله

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны
өдрийн А/89 дугаар албан бичгийн хавсралт

Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 6 дугаар хорооны "Мөнх-Үжин" ӨЭМТ

№	Эд хөрөнгийн нэр	Марк үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад авсан он	Нэгж үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл /2025.06.30/	Нийт үлдэгдэл	Шилжүүлэн авах байгууллага
1	Зөөврийн эхо аппарат VDA073A	VDA073A	ш	1	2024.08.05	14,443,000.00	14,443,000.00	2,647,883.37	11,795,116.63	Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв
Машин, тоног төхөөрөмжийн дүн							**14,443,000.00**	**2,647,883.37**	**11,795,116.63**	